



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

додуу \_\_\_\_\_ оны 10 сарын 16 өдөр

Дугаар Д.Дэлгэрсайхан.

Улаанбаатар хот

С.Даваадоржид ёс зүйн хариуцлага  
хүлээлгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 12 дугаар зүйлийн 12.1.5, 16 дугаар зүйлийн 16.1.3, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч Самбуугийн Даваадорж нь төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага, хэм хэмжээг зөрчсөн нь. Ёс зүйн дэд хорооны 09 дүгээр сарын 24-ний өдрийн дүгнэлт, Тамгын газрын 2/32 дугаар илтгэх хуудсаар тогтоогдсон тул түүнд 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс "Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах" ёс зүйн хариуцлага ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, ёс зүйн нийтлэг шаардлага, хэм хэмжээг мөрдөн, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын ахлах бүртгэгч С.Даваадоржид үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар (Г.Анхныбаяр)-т, Нийслэлийн Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс (Ө.Өлзийбаасан)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142402380